



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.14, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Газрын албан хаагчдын албан хэрэгцээнд хэрэглэгдэх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр хангах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас, хэрэглэлд зарцуулагдах 8,640,000 (Найман сая зургаан зуун дөчин мянга) төгрөгийг хөдөлмөр хамгааллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Худалдан авах ажлыг зохион байгуулах, албан хаагчдад хувцас хэрэгслийг актаар хүлээлгэн өгөх, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай..

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ